

БАТЛАВ:
САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА

О.БУЯНАА

САЙХАН СУМЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХӨТӨЛ
ХОТЫН ТӨВ,ЖИМСТЭЙ ХОРООЛОЛД ҮНИЙН САНАЛ АВАХ
БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, Хөтөл хотын төв, жимстэй хороолол

Төслийн дугаар:СЭАСХСЗДТГ/202001006

Сайхан сум
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.04.27

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, Хөтөл хотын төв, жимстэй хороололд **СЭАСХСЗДТГ/202001006** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн 10 цаг 40 минутад нээнэ.

Уг тендер нь цахим худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn сайтаар орж өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч www.tender.gov.mn сайтаар дамжуулан цахим хэлбэрээр ирүүлнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Сэлэнгэ аймаг, Сайхан сумын ЗДТГ,
ЗДТГазрын байр, Б корпус, 3 тоот өрөө
Засаг даргын орлогч Б.Үүрдмөнх
Утас: 99107630, 99880344

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨЭЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨЭЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тайлан 2018 оны аудитаар баталгаажуулсан тайлан, 2019 оны татвараас баталгаажуулсан тайлан. 2. Борлуулалтын орлого /2018, 2019 оны аль нэг жилд/ 30 сая төгрөгөөс дээш байх 3. Сүүлийн хоёр жилийн /2018, 2019 оны аль нэг жилд/ туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт, өмнөх захиалагчийн тодорхойлолт, гүйцэтгэсэн ажлын фото зургын хамт/ 4. Туршлагын мэдээллийн хувьд өмнө жилүүдэд цамхагт гэрэлтүүлэг хийж байсан туршлагатай бол давуу тал болно. 5. Инженер техникийн ажилтаны судалгааны хүснэгтээр гаргаж, ажилтан бүрийн танилцуулга, инженер техникийн ажилтаны мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар хамт ирүүлэх. 6. Тендерт оролцогч нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. 0,4 кВт-аас 15 кВт-ийн цахилгаан угсралтын тусгай зөвшөөрөл. 2. Барилга хот байгуулалтаас олгодог 2.2.8 Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистрал/ шугам /35кВ хүртэл/ угсрах тусгай зөвшөөрөл. /аль нэг нь байж болно/ <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг харуулсан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /Наториатаар баталгаажуулсан байх/ 2. Ажлыг гүйцэтгэх үе шатны ажлын хуваарь, нарийвчилсан хугацааны график ирүүлнэ 3. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсвийг эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. 4. Тендерт оролцогч нь уг ажлыг санал болгосон үнийн саналд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг гарган ирүүлнэ. Баталгаа ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. 5. Тендерт оролцогч нь өөр ажил гүйцэтгэж байгаа бол зөвхөн тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулах инженер, техникийн ажилтан, туслах ажилтаныг санал болгох бөгөөд давхацсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Тодорхойлолтууд: Доорх тодорхойлолтууд /2020 оны 04 дүгээр сарын 13/-ний өдрөөс хойш огноогоор гарган ирүүлэх/</p> <ol style="list-style-type: none"> 1. Татварын газрын бар код бүхий цахим тодорхойлолт /дутуу төлөлт 0 байх, эх хувь/ 2. Харьяалагдах банкны тодорхойлолт /Тус банкинд тулгамдсан өргүй байх/ 3. Шүүхийн байгууллагын тодорхойлолт /Эх хувь// 4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын тодорхойлолт /Эх хувь/ <p>-Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай тул хүснэгтээр гарган ирүүлэх мөн тус бүр өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м эзэмшлийг нотлох баримт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Угсралтын агергат 2. Шаттай машин 3. Гагнуурын аппарат
ТӨЭЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:

	<p>Байгууллагын хаяг: Сайхан сумын Засаг даргын тамгын газрын байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2-р давхарт 03 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 04 -ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Сайхан сумын Засаг даргын тамгын газрын байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2-р давхарт 03 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 05 дугаар сарын 04 -ний өдөр</p> <p>Цаг: 10 цаг 40 минут цахим хэлбэрээр нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Төсөвт өртөг: 40,000,000 төгрөг</p> <p>Заавал тооцож ирүүлэх зардал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Захиалагчийн албаны зардал -673,045 төгрөг 2. Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн- 1,346,092 төгрөг 3. Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал -336,523 төгрөг 4. Магадлашгүй ажлын зардал: -673,045 төгрөг
Дотоодын давуу эрх тооцох	<p>Дотоодын давуу эрх тооцно.</p> <p>Дотоодын давуу эрх тооцуулахаар сонирхсон этгээдийг дараах аргачлалаар тооцно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 заалтын дагуу /орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан/ үнэлгээ хийнэ. 2. Дээрх заалтаар дотоодын давуу эрх тооцуулах этгээд нь ажиллах хүчний иргэний үнэмлэх, хөдөлмөрийн гэрээ, дотоодын давуу эрх тооцуулах албан тоот зэргийг тусгайлан файл болгон ирүүлэх.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

СУУРИЙН АЖИЛ

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлгийн шонгийн нүх ухах	1 тулгуур	2
2	Бетон шахах шахуургаар баганы 3м3 хүртэл бетон суурь цутгах	М3	4.55
3	20 кг аас дээш жинтэй бэхэлгээний деталь төмөр суулгах	Тн	0.12
4	Бетон ба дэвсгэр үеийг арматурчилах	Тн	0.1

ЦАМХАГТ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	15 м өндөртэй дан шонг өрөмдөн өргөгч кран машинаар босгох	1 шон	2
2	Төмөр гадаргууг зэврэлтээс хамгаалах ростекс суурь будгаар будах / багсаар/	М2	9
3	Шонд тавих гадна талбайн лед гэрэлтүүлэг тус бүр нь 500 вт угсрах	Ширхэг	12
4	Сип 2х16 мм2 тэжээлийн кабель татах	М	300
5	1 фазын тоолуур угсрах электрон ухаалаг тоолуур	Ширхэг	2
6	Гэрэлтүүлгийн самбар угсрах жин 28 кг иж бүрэн	Ширхэг	2
7	Хугацааны реле солих	Ширхэг	2

ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖИЛ

№	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлгийн шон суулгах нүх гараар ухах	М3	25
2	Гэрэлтүүлгийнэ бетон суурь цутгах	М2	3.55
3	Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсрах / үйлдвэрийн төмөр шон!	Ширхэг	11
4	Төмөр бетон тулгуурыг анкерийн хавтантай троссоор татаж бэхлэх	Ширхэг	4
5	Гэрэлтүүлгийн бетон суурь цутгах	М3	3
6	20 кг хүртэл жинтэй бэхэлгээний деталь төмөр суулгах	Тн	0.2
7	Сип 2х16мм2 тэжээлийн кабель татах	М	385
8	Гэрэлтүүлгийн самбар угсрах жин 50 кг хүртэл	Ш	1
9	1 фазын тоолуур угсрах электрон ухаалаг тоолуур	Ш	1

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Сайхан сумын засаг дарга О.Буянаа танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших
 - 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
 - 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх
 - 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх
 - 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа
 - 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах
 - 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр
 - 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан моо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь
 - 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах
 - 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах
 - 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх
 - 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэлгаргана.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;

3 Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

4 Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]